

ТҮР ЗУУРЫН, ЗАЙ ХАДГАЛАГЧ ШҮДЭЛБЭРИЙН ЗААВАР (DENTAL TEMPORARY PARTIAL/FLIPPER INSTRUCTIONS)

ЯМАР ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙХ ВЭ:

- “Түр зуурын” буюу “завсар хоорондын” эсвэл “флиппер” хиймэл шүдэлбэр нь түр хугацаанд зүүх, гоо сайхны зориулалттай шүд орлуулагч юм.
- Энэхүү хиймэл шүд нь удаан хугацаанд ашиглах, мөн хоол идэх эсвэл унтах үед хэрэглэх зориулалтгүй.
- Хэрэв хиймэл шүд зүүхэд эвгүй байвал шүдний эмч тохируулж өгөх хүртэл түр зүүхээ зогсооно уу.

ЮУ ХИЙХ ВЭ:

- Хиймэл шүдээ зүүгээгүй үедээ хиймэл шүдийг устай хуванцар саванд хадгална.
- Хиймэл шүдийг цэвэр байлгахын тулд усанд хиймэл шүд цэвэрлэгч шахмал нэмнэ.
- Хиймэл шүдний хоёр талын гадаргууг өдөр бүр шүдний сойзоор цэвэрлэнэ.
- Хиймэл шүдээ зүүгээгүй үедээ гэрийн тэжээвэр амьтдаас хол байлгана. Амьтад хиймэл шүдийг зажиллах хандлагатай байдаг.

ЮУ ХИЙЖ БОЛОХГҮЙ ВЭ:

- БОЛОХГҮЙ: хиймэл шүдтэйгээ хоол идэж болохгүй, ингэснээр хиймэл шүд хугарах эрсдэлтэй.